



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/644

Ховд

Ургамал захын дээд талын талбайн тохижилт  
/Жаргалант сум, Алагтолгой баг/ -н ажлыг  
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Тахидаг хар" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Ургамал захын дээд талын талбайн тохижилт /Жаргалант сум, Алагтолгой баг/-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга -Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Б.Ганзориг - Мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын Улсын байцаагч

Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

З.Өмиртай - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Б.Нямсүрэн - Жаргалант сумын Алагтолгой багийн Засаг дарга

Ц.Цолмонбаатар - Стандарт хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

- С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга
- Э.Алтан-Од - Барилгын зураг төслийн  
“Алтан орд констракш” ХХК-ийн захирал
- Ц.Отгонцэцэг - “Тахидаг хар” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн  
дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын мэргэжилтэн

2. “Тахидаг хар” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Туулайтулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН